



ХУР ЭРДЭНЭ БАЯЛАГ ХХК

**ӨМНӨГОВЬ АЙМАГ, НОЁН СУМЫН НУТАГТ ОРШИХ
“БАРУУН НОЁН УУЛ” НҮҮРСНИЙ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ
ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**



2026 он

БАТЛАВ:
БАЙГАЛЬ ОРЧИН, УУУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ,
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БОДЛОГО, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА

..... /Г.ЭНХМӨНХ/

БАТЛАВ.
ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:
“ХУР ЭРДЭНЭ БАЯЛАГ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

...../ДУН ШИАН РИУ/

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН НОЁН СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “БАНУУН НОЁН УУЛ”
НҮҮРСНИЙ УУРХАЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР-MV-017301/

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГЕСТРИЙН ДУГААР-5671833/

ХЯНАСАН:

БОУАӨЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БОДЛОГО, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН

...../ /

БОЛОВСРУУЛСАН:

“ХУР ЭРДЭНЭ БАЯЛАГ” ХХК-НИЙ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН:

...../ О.ТҮВШИНТӨР /

АГУУЛГА

ЗУРГИЙН ЖАГСААЛТ	4
ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ	4
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	5
1.1. Төслийн нэр	5
1.2. Төсөл хэрэгжүүлэгч компани	5
1.3. Уурхайн хүчин чадал	5
1.4. Төслийн байршил	6
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ТАЛБАЙН БАЙРШИЛ, ФИЗИК ГАЗАРЗҮЙН НӨХЦӨЛ	8
2.1. Төсөл хэрэгжих орчны газарзүйн онцлог	8
2.2. Физик газарзүй, өндөржилт	9
2.3. Ус зүй	10
2.4. Хөрсөн бүрхэвч	10
2.5. Ургамлан бүрхэвч	12
2.6. Амьтны аймаг	13
ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	14
3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	15
3.1.1. Агаар орчны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	15
3.1.2. Гадаргын ба газрын доорхи усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	16
3.1.3. Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	17
3.1.4. Газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	18
3.1.5. Ургамлын аймаг, ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	19
3.1.6. Амьтны аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	20
3.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	21
3.3. Биологийн олон янз байдал, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	22
3.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө ..	23
3.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	23
3.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	24
3.7. Хог хаягдлын менежмент төлөвлөгөө	25
3.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	26
3.9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	28

3.10. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	29
3.11. 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зарцуулах нийт зардал	29
ДҮГНЭЛТ	31

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1-1. Төслийн талбайн байршлын зураг	6
Зураг 2-1. Байгалийн бүс бүслүүр.....	8
Зураг 2-2. Өндөржилтийн зураг.....	9
Зураг 2-3. Өндөржилтийн зураг.....	10
Зураг 2-4. Хөрс газарзүйн мужлалтын зураг	11
Зураг 2-5. Төслийн талбай орчмын хөрсний зураг	11
Зураг 2-6. Ургамал газарзүйн мужлалтын зураг	12
Зураг 2-7. Төслийн талбай орчмын ургамлан бүлгэмдлийн зураг	12

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1-1. Төслийн товч танилцуулга.....	5
Хүснэгт 1-2. Уурхайн ажиллах горим	6
Хүснэгт 1-3. Тусгай зөвшөөрлийн талбайн солбицлын цэгүүд.....	6
Хүснэгт 3-1. Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд	14
Хүснэгт 3-2. Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	15
Хүснэгт 3-3. Усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	16
Хүснэгт 3-4. Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	17
Хүснэгт 3-5. Газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд	19
Хүснэгт 3-6. Ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд	20
Хүснэгт 3-7. Амьтны аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд	20
Хүснэгт 3-8. Нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө	21
Хүснэгт 3-9. Биологийн олон янз байдал, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	22
Хүснэгт 3-10. Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын арга хэмжээний төлөвлөгөө	23
Хүснэгт 3-11. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	23
Хүснэгт 3-12. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	24
Хүснэгт 3-13. Хог хаягдлын менежмент төлөвлөгөө	25
Хүснэгт 3-14. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	26

Хүснэгт 3-15. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	28
Хүснэгт 3-16. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	29
Хүснэгт 3-17. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал.....	29

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн нэр

Өмнөговь аймгийн Ноён сумын нутагт орших “Баруун Ноён Уул” нэртэй чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах төсөл.

1.2. Төсөл хэрэгжүүлэгч компани

Төсөл хэрэгжүүлэгч “Хур Эрдэнэ Баялаг” ХХК нь 2013 онд уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа явуулахаар үүсгэн байгуулагдсан Монгол улсын 9019071068 тоот улсын бүртгэлийн дугаартай, 100% БНХАУ-ын хөрөнгө оруулалтай аж ахуйн нэгж юм.

Төсөл хэрэгжүүлэгч нь MV-017301 тоот ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийг эзэмшдэг ба өөр чиглэлээр үйл ажиллагаа явуулаагүй, зөвхөн энэ төсөл дээр төвлөрөн ажиллаж байгаа юм.

Хүснэгт 1-1. Төслийн товч танилцуулга

Аж ахуйн нэгжийн нэр	“Хур Эрдэнэ Баялаг” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	39019071068
Регистрийн дугаар	5671833
Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл	MV-017301
Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгосон огноо	2013.04.17
Ашиглалтын талбай	1085.2 га
Төслийн байршил, хаяг	Өмнөговь аймаг, Ноён сум хот, Сайран баг, Цагаан дэрс

1.3. Уурхайн хүчин чадал

2022 оны эцсийн байдлаар төсөл хэрэгжүүлэгчийн техникийн чадамж нь жилд 3000.0 мян.м³ уулын цул гаргах боломжтой байна. 2023 онд төсөл хэрэгжүүлэгч нь техникийн хүчин чадлаа нэмэгдүүлж жилд 8.2 сая м³ уулын ажил явуулах боломжтой болж байна. Уурхайн хүрээ хязгаарт багтсан нөөцийг энэ хүчин чадлаар 2 жилийн хугацаанд ашиглах боломжтой байна.

Уурхай нь одоогийн байдлаар 14/14 хоногийн уртын ээлжинд бүрэн шилжиж өдөр, шөнө 12 цагаар үргэлжлэх 2 ээлжээр ажиллаж байна. Ээлжинд цэвэр ажлын 10 цаг ажиллах буюу цаг ашиглалтын коэффициент 0.83 байна.


Жилд баяр ёслол, амралтын өдрүүд, төлөвлөгөөт засвар, цаг ашиглалтын коэффициент 0.83 байна. Жилд баяр ёслол, амралтын өдрүүд, төлөвлөгөөт засвар, цаг агаарын болзошгүй саатлаас шалтгаалж цэврээр 330 хоног ажиллахаар ТЭЗҮ-д тооцоолсон.

Хүснэгт 1-2. Уурхайн ажиллах горим

№	Үзүүлэлт	Нэгж	Утга
1	Хуанлийн хоногийн тоо	хоног	365
2	Баяр ёслол, сул зогсолт	хоног	35
3	Жилд ажиллах өдрийн тоо	хоног	330
4	Ээлжийн үргэлжлэх нийт хугацаа	цаг	12
5	Хоногт ажиллах ээлжийн тоо	ээлж	2

1.4. Төслийн байршил

“Баруун Ноён Уул” нэртэй MV-017301 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай нь Өмнөговь аймгийн Ноён сумын нутагт бөгөөд Улаанбаатар хотоос 780 км, Өмнөговь аймгийн төв Даланзадгад хотоос баруун тийш 210 км, Ноён сумын төвөөс зүүн тийш 30 км зайд оршино.



Зураг 1-1. Төслийн талбайн байршлын зураг


Хүснэгт 1-3. Тусгай зөвшөөрлийн талбайн солбицлын цэгүүд

№	Уртраг	Өргөрөг
1	102° 23' 4.9"	43° 6' 0.26"
2	102° 23' 4.9"	43° 5' 29.58"
3	102° 30' 0.89"	43° 5' 29.58"
4	102° 30' 0.89"	43° 5' 1.29"
5	102° 22' 0.8"	43° 5' 1.31"
6	102° 22' 0.8"	43° 6' 0.26"

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ТАЛБАЙН БАЙРШИЛ, ФИЗИК ГАЗАРЗҮЙН НӨХЦӨЛ

2.1. Төсөл хэрэгжих орчны газарзүйн онцлог

Өмнөговь аймгийн Ноён сум нь Монгол орны физик газарзүйн мужлалаар газрын гадаргын хувьд Алтайн уулархаг их мужийн Говийн-Алтайн мужид багтдаг. Төслийн нутаг дэвсгэрт Эхэн хайлааст уул (1873м), Дэнгийн нуруу (1975м), Дөрвөлжин уул (1612м)-с орших бөгөөд талбайн ойролцоох уулс толгод нь д.т.дээш 1600-1900м, мөн Гурвантэс-Борзонгийн говийн элсний мужид хамаарагдах Жарангийн элс байрлана. Уулсын онцлог нь гүн сайраар нилээд хэрчигдсэн, маш эгц хажуутай, харьцангуй тэгш хэмт байдалтай юм. Уулсаас эх авсан сайрууд нь хуурай зарим хэсэгтээ овоо өргөн бөгөөд урт нь хэдэн км-ээс хэдэн арван км хүрнэ.



Зураг 2-1. Байгалийн бүс бүслүүр

Аймгийн нутаг нь говь цөлийн мужид багтах бөгөөд дунджаар далайн түвшнээс дээш 1300-1600 м өндөрт оршино. Энд Алтайн нурууны үргэлжлэл Гурвансайхан, Сэврэй, Ноён богд, Номгон, Тост, Нэмэгт, Алтан уул, Гилбэнт зэрэг далайн түвшнээс дээш 3000 м хүртэл өндөр өргөгдсөн уул нурууд болон 100 гаруй км үргэлжилсэн Хонгорын элс, хэдэн 100 км өргөн Галба, Борзон, Зээмэг, Заг, Сүүжийн алдарт их говиуд бий.


Тус орд нь нутаг дэвсгэрийн мужлалын хувьд Алтайн уулархаг мужийн Говь-Алтайн мужийн Говь-Алтайн зүүн тойрогт багтдаг.

Олборлолтын талбай нь Эхэн Хайлаастын синклиналийн баруун хойт хэсэгт байрших ба нүүрсний давхраас агуулагч дээд пермийн Дэлийн шанд формацын хурдас нь хойт хэсгээрээ дунд-дээд карбоны Тост формацын андезит-базальтаас тогтох эффузив зузаалаг болон түүнийг зарим хэсгээрээ тасалдалтайгаар хучих доод пермийн

Тогоот хар формацын риолит, риодацитаас тогтох хүчиллэг зузаалаг дээр угаagdлын гадаргуугаар хилэлдэг болно. Дэлийн шанд формац хайгуулын талбайн энэ хэсэгт бараг бүхэлдээ дээд дөрөвдөгч-орчин үеийн сэвсгэр хурдсаар хучигдах боловч гуу жалгаар хэрчигдэж идэгдсэн хэсгийн хоёр захаар байнга ил гардаг гаршийн уналын азимут нь $170-200^{\circ}$, налуугийн өнцөг нь $35-40^{\circ}$ байна.

2.2. Физик газарзүй, өндөржилт


Монгол орны физик газарзүйн мужлалтаар Алтайн уулархаг их муж, Говь Алтайн дэд муж, Говь Алтайн зүүн захын тойрогт хамаарна. Эхэн хайлааст уул (1873м), Дэнгийн нуруу (1975м), Дөрвөлжин уул (1612м)-с орших бөгөөд талбайн ойролцоох уулс толгод нь т.т.дээш 1600-1900м харьцах өндөртэй.



Зураг 2-2. Өндөржилтийн зураг

Тус ордын талбай нь газрын гадаргын хувьд Говь-Алтайн уулсын дундах тал хээрийн бүсэд орших ба ихэнх хэсэг нь бэсрэг уулс толгодорхог гадаргуутай газруудыг хамарна.

Талбайн хамгийн өндөрт өргөгдсөн цэг нь талбайн хойд хэсэгт карьерын зүүн хойно орших далайн түвшнээс дээш 1703 м өндөрт өргөгдсөн уулын орой болно. Хамгийн нам цэг нь далайн түвшнээс дээш 1560 м өндөртэй талбайн зүүн өмнөд хэсэг дэх жалга болно.



Зураг 2-3. Өндөржилтийн зураг

2.3. Ус зүй


Ус зүй, гадаргуугийн усан сүлжээний хувьд Төв Азийн гадагш урсгалгүй ай савд багтдаг бөгөөд тогтмол урсацтай гол горхи, нуур, цөөрөм байхгүй гадаргын ус ховортой бүсэд багтана. Энд зөвхөн уулс хоорондын хотгорт жижиг шал, тойром бүхий газарт хур бороо ихтэй үед уулсын жижиг ам, хөндий хуурай сайраар түр зуурын урсац бүхий ус урсаж хотгоруудын ёроолд хурж тогтох ба сэвсгэр хурдсан доогуур шурган замхардаг.

Талбайн хэмжээнд байнгын урсгалтай гол горхи бараг байхгүй боловч зарим үедээ усны ажиллагаа нилээд идэвхждэг болохыг гэрчлэх ор мөр цөөнгүй бий. Талбайд уртрагийн дагуу чиглэлтэй голын хуурай сайр түүнд цутгах жижиг сайрууд, хэрчигдэл багатай хөндийнүүд хөгжсөн байна. Цас их орж хайлах үргэлжилсэн бороо орох зэрэг үед эдгээр сайр нь бага зэрэг устай болох боловч бороо татрахад усгүй болно. Хур бороотой үед жижиг хонхор хотгор газарт жижиг нуурууд бий болох ба тэдгээр нь элс, булингартай усаар дүүрдэг. Хүн малын унданд бага гүнтэй, гар худгийн ус хэрэглэх бөгөөд худгуудыг голчлон хуурай сайр, нуурын зах хөвөөг бараадуулан гаргасан байдаг. Худгийн түвшин нь 5-6 м-т заримдаа 9-10 м-т хүрдэг.

2.4. Хөрсөн бүрхэвч


Монгол орны ургамал, газарзүйн мужлалаар Алтайн уулархаг их мужийн ГовьАлтайн зүүн тойрогт багтах ба энэ талбайн хөрс нь Монгол орны байгалийн бүсийн хуурай хээр, заримдаг цөлийн бүсэд хамрагдана.

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН НОЁН СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “БАРУУН НОЁН УУЛ” НҮҮРСНИЙ УУРХАЙН
2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**



Зураг 2-4. Хөрс газарзүйн мужлалтын зураг


Говийн цайвар бор хөрс, уулын цөлөрхөг хээрийн бор саарал хөрс, хужирлаг говийн бор саарал, цөлөрхөг хээрийн бор хөрс, уулын цөлийн бор саарал хөрс, цөлөрхөг хээрийн бор хөрс, элсэрхэг говийн бор хөрс зэрэг хэв шинжийн хөрс тархсан байна.




Зураг 2-5. Төслийн талбай орчмын хөрсний зураг

2.5. Ургамлан бүрхэвч

Ургамлын хувьд Монгол орны ургамал-газарзүйн мужлалаар Өмнөговь аймаг нь Говь- Алтайн уулын цөлөрхөг хээр, Алашаа говь, Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт багтдаг. Ургамлын зүйлийн бүрдлийн 21.4% нь хуурайсаг, 21.3% нь хуурайсуу чулуусаг, 15.5% нь чийгсүү-давссаг, 10.2% нь чийгсүү-хуурайсаг, 6.5% нь элсэн дасалттай ургамал бөгөөд сөөг, сөөгөнцөр ургамлын бүлгэмдэл зонхилно.



Зураг 2-6. Ургамал газарзүйн мужлалтын зураг



Зураг 2-7. Төслийн талбай орчмын ургамлан бүлгэмдлийн зураг

2.6. Амьтны аймаг

Амьтдын хувьд Өмнөговь аймгийн нутаг дэвсгэр нь амьтны аймгийн газарзүйн мужлалаар Хойт говь, Говь-Алтай, Алтайн өвөр говийн тойрогт багтана. Уг нүүрсний орд орчмын газар нутагт том хөхтөнөөс Янгир ямаа, хар сүүлт тэмдэглэгдсэн байна. Жижиг хөхтөн, хоёр нутагтан ба мөлхөгчид зэрэг зарим амьтдын зүйлийн бүрдлийг харвал Цөлийн хөхтөний бүлгэмдлээс Боролзон туулай, Элссэг зузга, Бордуу шишүүхэй, шаргал чичүүл, морин цөцүүл, шивэр алаг даага, Өмнөговийн алаг даага, Элсч савгадаахай, Гувруу тажигдаахай зэрэг амьтад байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго, зорилт: Өмнөговь аймгийн Ноён сумын нутагт Баруун Ноён Уул нүүрсний ордын ашиглалтын үйл ажиллагааны Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ 2018, 2024 онуудад батлагдсан тайлангуудын хүрээнд тогтоогдсон төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллах үндсэн зорилготой.

2025 онд байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр нэн тэргүүнд тавих зорилтот ажлууд нь компаний байгаль орчны бодлого удирдлагын тогтолцоог бий болгох, хог хаягдлын менежментийн сайжруулах ажлуудыг зорилт болгон ажиллана.

Хамрах хүрээ: Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 2025 оны Баруун Ноён Уул ордын ашиглалтын үйл ажиллагааны бүх үе шатыг хамарна. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Монгол улсын Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолоор баталсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”, БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А-618 журмын 3 дугаар хавсралтаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-уудыг тус тус баримталснаас гадна байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд тулгуурласан болно.

Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын тоон үзүүлэлтийг дараах хүснэгтэд нэгтгэн үзүүлэв.

Хүснэгт 3-1. Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд

Д/д	Байгаль орчны хамгаалах арга хэмжээний төрөл	Төлөвлөсөн ажлын тоо
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	22
2	Нөхөн сэргээлт	1
3	Биологийн олон янз байдал дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	3
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	1
5	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	1
6	Осол эрсдлийн менежмент	4
7	Хог хаягдлын менежмент	8
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	4
9	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	5
10	Нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	3
Нийт		52

3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

3.1.1. Агаар орчны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 3-2. Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжих хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг	
1	Хатуу хучилтгүй зам дээрх тээврийн хөдөлгөөн, Нүүрс тээврийн зам дагуух тоосжилт үүсэх	Замын тоосжилтыг бууруулах зорилгоор усалгаа хийх (дулааны улиралд усалгааг тогтмол хийх)	Уурхайн технологийн зам, туслах зам, нүүрс агуулах талбай	тн/км	0.797	2100	1673.0	Тогтмол	Монгол улсын Агаарын тухай хууль MNS4585:2016 Агаарын чанарын стандарт-Техникийн ерөнхий шаардлага	
2		Замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор замын засвар, арчилгаа хийх		км	1500.0	1	1500.0	Тогтмол		
3		Замаас үүсэх тоосжилтыг бууруулах-хурдны хязгаарыг дагаж мөрдүүлнэ. (шаардлагатай бол хурдны хязгаарын тэмдэг, тэмдэглээ байрлуулах)	Уурхайн технологийн зам, туслах зам, нүүрс агуулах талбай	км	500.0	--*--	500.0	Улиралд нэгудаа		
4		Ажилчдыг эрүүл ажиллах, амрах орчинг бүрдүүлэх зорилгоор уурхайн тосгоны ногоон байгууламжийн усалгаа арчилгааг тогтмол хийх	Уурхайн тосгон	м ²	5302.18	1	5302.18	Нэг удаа		MNS 6260:2020 Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах
5										
Нийт мян.төг				8975.88						

3.1.2. Гадаргын ба газрын доорхи усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 3-3. Усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжих хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Төслийн үйл ажиллагааны хүрээнд газрын доорхи ус ашигласнаар газрын доорхи усны нөөц хомсдох	Уурхайн ундны усны хэрэглээг тогтмол бүртгэх, ашиглах усны хэмжээг зорилгод түвшинд байлгах, усны төлбөрийг цаг тухай бүрт төлж, байгаль хамгаалагчаар баталгаажуулах	Уурхайн тосгон	м ³	0.0997	Баталгаажуулсан усны тоолуурын заалтаар	538.38	Тогтмол	MNS0900:2018 Хүрээлэн буй орчин, Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ” - MNS4943:2015. Хүрээлэн байгаа орчин. Усны чанар, хаягдал ус. Ерөнхий шаардлага”
2		Уурхайн ногоон байгууламжийн усалгаанд уурхайн шүүрлийн ус, цэвэрлэгдсэн саарал усыг дахин ашиглах	Уурхайн хэсэг	м ³	0.79794		2659.8	2, 3-р улирал	
3		Усны зохистой ашиглалтын талаар сургалт явуулах	Уурхайн нийт ажилчид	ш	200.0	1.0	200.0	Хагас жил тутам, Шинээр ажилд орж буй бүх ажилчид сургалтад хамрагдах	
4		Усыг үр ашигтай хэрэглэх талаарх мэдээллийн хуудсыг зарын самбарт байрлуулж шинэчилж байх			100.0	2.0	200.0	Үйл ажиллагааны туршид	



“ӨМНӨГОВЬ АЙМГИЙН НОЁН СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “БАНУУН НОЁН УУЛ” НҮҮРСНИЙ УУРХАЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжих хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
5		Уурхайн карьерт шүүрч буй усыг тогтмол шавхаж зам талбайн тоосжилтыг багасгах зорилгоор ашиглах	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	м ³			Дотоод зардлаар		
6	Зөвшөөрөлгүйг ээр усыг ашигласнаар усны нөөц хомсдох	МУ-ын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг усны газраас ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлт гаргуулах, Алтайн өвөр говийн сав газрын захиргаанаас ус ашиглах зөвшөөрөл авч гэрээ байгуулан ажиллах	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд	м ³			Дотоод зардлаар	Жилд 1 удаа	
Нийт мян.төг			3598.18						

3.1.3. Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Уурхайн хаалтын нөхөн сэргээлтэд стратегийн чухал ач холбогдол бүхий шимт болон шимэрхэг хөрсийг хамгаалах хөрсийг зөв хуулах, хадгалах, чанарын үзүүлэлтүүдийг хянах зэрэг шаардлагуудыг ханган, хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахад дараах арга хэмжээнүүдийг авч ажиллана.

Хүснэгт 3-4. Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжих хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Үржил шимт хөрс хуулагдах ба хадгалах явцад хөрсний үржил шим	Аливаа газар хөндөх үйл ажиллагааны өмнө шимт болон шимэрхэг хөрсний гүнийг талбай тус бүрд тогтоож,	Уурхайн үйл ажиллагааны туршид	га/м ³	*	Газар хөндөх зөвшөөрлийн хүсэлтээр	*	Жилийн турш	5916:2008 "Газар шорооны ажлын үед шимт хөрс



“ӨМНӨГОВЬ АЙМГИЙН НОЁН СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “БАРУУН НОЁН УУЛ” НҮҮРСНИЙ УУРХАЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжих хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
2	өөрчлөгдөх, доройтох ШТМ асгарч орчны хөрсөн бүрхэвчийг бохирдуулах Ахуйн хатуу хог хаягдлаар хөрс бохирдох, орчны эрүүл ахуйн байдал алдагдах	тогтоосон хэмжээнд хуулж, бүртгэл хөтлөх, хаягжуулах						Жилийн турш	хуулалт, хадгалалт
		Газарзүйн мэдээллийн системд шимт, шимэрхэг хөрсний овоолгын байршил, хэмжээг бүртгэх, зурагжуулах, тухайн овоолгыг газар дээр нь хаягжуулах							
		ШТМ хөрсөнд алдагдахаас сэргийлэх							
		Олон салаа авто замаар хөрс эвдэрхээс сэргийлж нэг замын маршрутаар зорчих, нэг замын маршрутыг дотооддоо батлуулж мөрдөж ажиллах, хяналт тавих, гэрээт байгууллагуудад мөрдүүлэх							
3			л/м ²	1000.0	2.0	2000.0			
4			км	Дотоод журам			Жилийн турш		
Нийт мян.төг			2000.0						

3.1.4. Газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Газар хөндөх зөвшөөрөл олгох уурхайн дотоод журмын хэрэгжилтийг ханган, газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч ажиллана.



Хүснэгт 3-5. Газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжих хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ил уурхайн ухаш үүсэж газрын гадарга, газрын хэвлийн үндсэн тогтоц өөрчлөгдөх	Зайнаас тандан судлах аргазүйг ашиглан газар ашиглалтыг хянах, зөвшөөрөлгүй газар хөндсөн тохиолдолд байгаль орчны зөрчлөөр бүртгэж, зөрчлийг арилгах шаардлагатай арга хэмжээг авах	Уурхайн үйл ажиллагааны туршид	га/м ³	Дотоод зардлаар			Жилийн турш	5916:2008 "Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт
2		Хяналтгүйгээр газар хөндөхөөс сэргийлж аливаа газар хөндөх үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө Газар хөндөх зөвшөөрөл (ГХЗ) авах, олгох, Газарзүйн мэдээллийн систем (ГМС)-д бүртгэл хөтлөх		га/м ³	1000.0	1	1000.0	Жилийн турш	
Нийт мян.төг						1000.0			

3.1.5. Ургамлын аймаг, ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Монгол Улсын ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд манай уурхай нь Өмнөговь аймгийн Баяндалай суманд 5 га талбайд заг (*Haloxylon ammodendron*) мод тарихаар төлөвлөж байна.

“ӨМНӨГОВЬ АЙМГИЙН НОЁН СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “БАРУУН НОЁН УУЛ” НҮҮРСНИЙ УУРХАЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 3-6. Ургамлан нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжих хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Уурхайн хүрээ хязгаар гадаад овоолго, уурхайн гадаад овоолго зам талбайн хэмжээгээр ургамлан нөмрөг, бэлчээрийн доройтол үүсэх	Байгаль орчны доройтол, цөлжилтийг бууруулах зорилгоор Монгол Улсын ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" хөдөлгөөний хүрээнд Баяндалай суманд мод тарих ажлыг төлөвлөж, хэрэгжүүлэх	Баяндалай сум	ш	5.0	6000	30000.0	III болон IV улирал	MNS 6140:2010 Техникийн шаардлага, MNS 6254:2011 Мод, сөөгний суулгацыг бойжуулах. Ерөнхий шаардлага
2		Уурхайн кемп, уурхайн эдэлбэр газар дах модлог ургамлын усалгаа, арчилгааг зохион байгуулах	Уурхайн бүс	*	Дотоод зардлаар				
Нийт мян.төг			30000.0						

3.1.6. Амьтны аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Өмнийн говийн бүс нутгийн зэрлэг амьтад, тэдгээрийн амьдрах орчинд учирч болох шууд болон дам нөлөөллийг бууруулах зорилгоор дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

Хүснэгт 3-7. Амьтны аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжих хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1		Уурхай орчимд тохиолдсон ховор амьтны бүртгэлийг хөтлөх	Уурхайн бүс	*	*	*	*	*	Ноён сумын байгаль орчны байцаагч болон байгаль
2		Автомат камерыг байршуулж зэрлэг амьтдыг бүртгэх, мэдээллийн сан үүсгэх	Ховор зүйлийн амьтдын зам дагуу	*	500.0	2.0	1000.0	Өвөл болон хаврын улиралд	



“ӨМНӨГОВЬ АЙМГИЙН НОЁН СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “БАРУУН НОЁН УУЛ” НҮҮРСНИЙ УУРХАЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжих хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
3		Төслийн талбай орчмын 5 км радиус дах ховордсон туруутан амьтдын ажиглалт судалгааг хийж, зурагжуулах	Ховор зүйлийн амьтдын зам дагуу	*			Дотоод зардлаар	Жилд 2 удаа	хамгаалагч нарын зөвлөмжийг үндэслэн зохион байгуулна
Нийт мян.төг			1000.0						

3.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Уурхайн ахилт, бүтээн байгуулалт, зам талбайн шимт хөрсийг хуулж овоолго үүсгэж, стандартын дагуу хамгаалж эвдрэлд өртсөн газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

Хүснэгт 3-8. Нөхөн сэргээлтийн арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжих хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Биологийн нөхөн сэргээлт	Шимт хөрсний овоолгыг салхины элэгдлээс хадгалж, хамгаалах зорилгоор олон наст ургамлыг тариалах	Уурхайн бүс	кг	10.0	400.0	4000.0	III болон IV улирал	MNS 5916:2008 "Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5917 : 2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага
Нийт мян.төг			14000.0						



3.3. Биологийн олон янз байдал, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

2022 онд “Эх монголын байгаль” ХХК-аар биологийн олон янз байдлын судалгаа, дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөөг хийж гүйцэтгүүлсэн. Уг ажлын хүрээнд Өмнөговь аймгийн Ноён сумын нутаг, Цагаан толгойн талыг сонгон авч дүйцүүлэн хамгаалах ажлын арга хэмжээг шат дараалалтай хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Хүснэгт 3-9. Биологийн олон янз байдал, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжих хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Цагаан толгойн талын амьтны амьдрах орчныг тэтгэх	Цагаан толгойн талын мэдрэгчээр ажилладаг худагт автомат камер байршуулж ажиглалт хийж, мэдээллийн сан үүсгэх	Цагаан толгойн талын ДХ талбай	*	Дотоод зардлаар			Жилийн турш	Биологийн олон янз байдлын судалгаа, дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөөний дагуу
2	Цагаан толгойн талын ургамлын аймаг, ургамлан бүрхэвчийг хамгаалах	Цагаан толгойн талд сухай тарих (талын гүний худагт түшиглэн)	Цагаан толгойн талын ДХ талбай	*	16.5	500	7250.0	III болон IV улиралд	Биологийн олон янз байдлын судалгаа, дүйцүүлэн хамгаалах ажлын төлөвлөгөөний дагуу
Нийт мян.төг			8250.0						

3.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

2022 онд уурхайн нөлөөллийн бүсийн 13 айлуудад бүрэн мэдээлэл өгч зөвлөлдсөний үндсэн дээр нүүлгэн шилжүүлэлт, эдийн засгийн нөхөн олговрын арга хэмжээг тодорхойлон хэрэгжүүлсэн. 2026 онд энэхүү арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллана.

Хүснэгт 3-10. Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжих хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	13 айл	Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн, 2026 онд үргэлжлүүлэн хэрэгжилтийг хангаж ажиллана.	Уурхайн нөлөөллийн бүсд хамрагдсан айл өрхүүд	Төслийн үйл ажиллагааны явцад тогтмол	Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай хууль, Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 58 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай” журам
Нийт мян.төг					-

3.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

